

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/17/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: А.Гэрэлмаа Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

СЭА-2024/17/НА-СТА-ОНА

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3.Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
4. Аудитын тайлан	15
4.1. Ерөнхий зүйл	15
4.2. Материаллаг байдал.....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	16
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18
5.1 Залруулга	18
5.2 Төлбөрийн акт	18
5.3 Албан шаардлага.....	19
5.4 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА А.АЛТАНСҮХ ТАНАА

2024.03.15 № СЭА-2024/17/НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчлийн нөлөөг эс тооцвол “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 37,173.7 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20.2.5, 20.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу тайлант онд үндсэн хөрөнгийн барилга, худаг услалтын системд дахин үнэлгээг Сор

үнэлэмж ХХК-иар хийлгэснээр үндсэн хөрөнгө 5,299,736.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд тус газар нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 75,264.5 мянган төгрөгийн “Цэвэр усны шугамын насос суурилуулах”, 86,825.2 мянган төгрөгийн “Үзлэгийн худаг угсрах” ажлууд болон аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 330,000.0 мянган төгрөгөөр экскаватор, 132,008.3 мянган төгрөгийн “Бохир усны шугамын ажил”-ыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцэст тайлагнагдсан 1,856,719.8 мянган төгрөгийн дансны авлагын 75.0 хувийг буюу 1,392,619.5 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 60.5 хувийг буюу 1,123,225.9 мянган төгрөгийг зөвхөн Сэлэнгэ энерго ААТҮГ-аас авах усны авлага эзэлж байна.

Дансны авлага өмнөх оноос 132,993.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь мөнгөн хөрөнгийн эргэлт, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2023	12/31/2023
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	21,757,101.45	1,679,746.53
1.1.2	Дансны авлага	1,723,726,723.66	1,856,719,811.33
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	280,072,850.06	275,372,750.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,182,105.26	2,243,198.54
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,029,738,780.43	2,136,015,507.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,417,118,543.64	4,509,582,127.88
1.2.2	Биет бус хөрөнгө	682,452,033.73	679,545,710.28
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,099,570,577.37	5,189,127,838.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,129,309,357.80	7,325,143,345.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	59,654,704.99	43,726,332.71
2.1.1.2	Цалингийн өглөг		463,989.22
2.1.1.3	Татварын өр	828,650,368.74	879,055,594.04
2.1.1.4	НДШ-ийн өглөг	832,055,362.45	1,028,493,788.97
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		10,123,157.70
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,720,360,436.18	1,961,862,862.64
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,698,800.00	6,698,800.00
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,698,800.00	6,698,800.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,727,059,236.18	1,968,561,662.64
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,574,064,600.00	1,574,064,600.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,326,522,257.69	5,161,385,136.32
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	657,289,718.94	1,364,716,091.53
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,155,626,455.01)	(2,743,584,145.28)
2.3.11	Эздийн өмчийн дүн	10,402,250,121.62	5,356,581,682.57
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,129,309,357.80	7,325,143,345.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,783,501,016.12	1,963,877,195.62
2	Борлуулалтын өртөг	2,365,987,677.83	2,500,793,163.39
3	Нийт ашиг(алдагдал)	(582,486,661.71)	(536,915,967.77)
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	21,650,600.00	19,600,545.45
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	88,036,073.93	55,284,440.97
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	24,220,361.00	15,357,826.98
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(673,092,496.64)	(587,957,690.27)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(673,092,496.64)	(587,957,690.27)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(673,092,496.64)	(587,957,690.27)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(673,092,496.64)	(587,957,690.27)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	208,993,441.16	(1,482,533,958.37)	10,627,046,340.48
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
3	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	208,993,441.16	(1,482,533,958.37)	10,627,046,340.48
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(673,092,496.64)	(673,092,496.64)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт			448,296,277.78		448,296,277.78
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
9	2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	657,289,718.94	(2,155,626,455.01)	10,402,250,121.62
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	1,574,064,600.00	10,326,522,257.69	657,289,718.94	(2,155,626,455.01)	10,402,250,121.62
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(587,957,690.27)	(587,957,690.27)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			707,426,372.59		707,426,372.59
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(5,165,137,121.37)			(5,165,137,121.37)
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,574,064,600.00	5,161,385,136.32	1,364,716,091.53	(2,743,584,145.28)	5,356,581,682.57

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,905,518,761.13	1,858,650,614.70
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,883,868,161.13	1,837,090,014.70
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	21,650,600.00	21,560,600.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,831,330,809.71	1,762,977,969.62
1.2.1	Ажиллагчдад төлсөн	810,356,530.00	863,373,443.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	155,436,929.00	76,485,280.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	353,821,913.71	316,214,564.34
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	269,480,499.16	281,681,627.78
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	80,261,230.80	112,909,633.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	4,068,302.97	6,521,360.93
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	121,108,949.79	90,434,233.59
1.2.9	Бусад мөнгөн зарлага	36,796,454.28	15,357,826.98
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	74,187,951.42	95,672,645.08
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	53,415,567.26	115,750,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,415,567.26	115,750,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(53,415,567.26)	(115,750,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	20,772,384.16	(20,077,354.92)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	984,717.29	21,757,101.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,757,101.45	1,679,746.53

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	ОРЛОГЫН ДҮН	м/төг	2,705,970.1	1,983,477.7	(722,492.4)	(0.3)
	Үйл ажиллагааны орлого	м/төг	2,684,320.1	1,963,877.2	(720,442.9)	(0.3)
	Татаас санхүүжилт	м/төг	21,650.0	19,600.5	(2,049.5)	(0.1)
2	ЗАРЛАГА ДҮН	м/төг	3,552,178.8	2,571,435.4	(980,743.4)	(8.9)
	Цалин	м/төг	1,315,554.6	1,051,912.2	(263,642.4)	(0.2)
	НД-ийн шимтгэл	м/төг	190,755.4	149,019.3	(41,736.1)	(0.2)
	ҮХ элэгдэл	м/төг	598,944.8	576,558.0	(22,386.8)	(0.0)
	Цахилгаан	м/төг	226,345.0	169,122.8	(57,222.2)	(0.3)
	Шатахуун	м/төг	108,000.0	87,461.8	(20,538.2)	(0.2)
	Дулаан	м/төг	147,895.8	160,697.0	12,801.3	0.1
	Буцалтгүй тусламж	м/төг	12,500.0	9,167.0	(3,333.0)	(0.3)
	Материал	м/төг	269,640.0	222,572.0	(47,068.0)	(0.2)
	Үндсэн хөрөнгө худалдан авалт	м/төг	149,100.0	-	(149,100.0)	(1.0)
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал	м/төг	84,710.0	2,342.5	(82,367.5)	(1.0)
	Холбоо	м/төг	14,468.8	10,169.6	(4,299.2)	(0.3)
	Сургалт	м/төг	10,600.0	5,554.4	(5,045.6)	(0.5)
	Томилот	м/төг	14,033.0	22,696.9	8,663.9	0.6
	Тээврийн хэрэгслийн татвар	м/төг	1,220.9	449.5	(771.4)	(0.6)
	Үл ХХ-ийн татвар	м/төг	-	9,364.4	9,364.4	-
	НӨАТ, ХАОАТ, суутган	м/төг	151,939.2	-	(151,939.2)	(1.0)
	Ус ашигласны татвар	м/төг	11,500.0	6,980.0	(4,520.0)	(0.4)
	Урсгал засвар	м/төг	136,600.0	22,051.6	(114,548.4)	(0.8)
	Программ хангамжийн зардал	м/төг	6,600.0	3,382.8	(3,217.2)	(0.5)
	Аудитын зардал	м/төг	3,000.0	3,000.0	-	-
	Даатгал	м/төг	5,530.0	842.2	(4,687.8)	(0.8)
	Хүү торгуулийн зардал	м/төг	6,600.0	6,521.4	(78.6)	(0.0)
	Зохицуулах үйлчилгээний хөлс	м/төг	9,961.4	4,000.0	(5,961.4)	(0.6)
	Харуул хамгаалалтын зардал	м/төг	37,800.0	30,000.0	(7,800.0)	(0.2)
	Бусад зардал	м/төг	38,880.0	17,570.1	(21,309.9)	(0.5)
3	Үйл ажиллагааны ашиг алдагдал (1-2)	м/төг	(846,208.7)	(587,957.7)	258,251.1	8.7
4	Орлогын татвар (3*10%)	м/төг				
5	ЦЭВЭР АШИГ, АЛДАГДАЛ (3-4)	м/төг	(846,208.7)	(587,957.7)	258,251.1	8.7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь *“Байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Уст цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Гадаад худалдаа гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Урсгал ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”*, 21 дүгээр зүйл *“Аймгийн чиг үүрэг”*, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь *“харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч, борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, татаас санхүүжилт, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, дахин үнэлгээ дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	21,757.1	1,679.7	(20,077.4)
Авлага	1,723,726.7	1,856,719.8	132,993.1
Татвар, НДШ-ийн авлага			-
Бараа материал	280,072.8	275,372.8	(4,700.0)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,182.1	2,243.2	(1,938.9)
Үндсэн хөрөнгө	10,099,570.6	5,189,127.8	(4,910,442.8)
Нийт хөрөнгийн дүн	12,129,309.3	7,325,143.3	(4,804,166.0)
Өр төлбөр	1,727,059.2	1,968,561.7	241,502.5

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	10,326,522.3	5,161,385.1	(5,165,137.2)
Эздийн өмч	75,727.8	195,196.5	119,468.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	12,129,309.3	7,325,143.3	(4,804,166.0)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,679.7 мянган төгрөг болж 20,077.4 мянган төгрөгөөр буурсан нь 1,890,441.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,910,519.0 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,856,719.8 мянган төгрөг болж 132,993.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн нэгжээс болон оршин суугчдаас авах үйлчилгээний төлбөрийн авлага өссөнөөс шалтгаалсан байна.

Нийт авлагын 75.0 хувийг буюу 1,392,619.5 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 15.5 хувийг буюу 286,957.4 мянган төгрөгийг айл өрхөөс авах усны, 7.0 хувийг буюу 130,336.9 мянган төгрөгийг байгууллагаас авах, 1.5 хувийг буюу 27,022.2 мянган төгрөгийг хувь хүнээс авах, 1.0 хувийг буюу 19,783.8 мянган төгрөгийг цалингийн, ажиллагсдаас авах авлага эзэлж байна.

Байгууллага, аж ахуйн нэгжээс авах 1,392,619.5 мянган төгрөгийн усны авлагын 80.7 хувийг эзэлж буй Сэлэнгэ энерго ААТҮГ-с авах усны авлага 1,123,225.9 мянган төгрөгийг барагдуулж чадахгүй байгаа нь мөнгөн хөрөнгийн эргэлт, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 275,372.8 мянган төгрөг болж 4,700.0 мянган төгрөгөөр өссөн нь 326,060.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 330,760.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,189,127.8 мянган төгрөг болж 4,910,442.8 мянган төгрөгөөр буурсан нь дараах ажил, гүйлгээнээс шалтгаалжээ. Үүнд:

- Өөрийн хөрөнгөөр 115,750.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан,
- Мэргэжлийн хяналтын газраас 885.0 мянган төгрөгийн хөрөнгө, Гавшгай ус ААТҮГ-аас 1,570.0 мянган төгрөгийн хатаах шүүгээг шилжүүлэн авсан,
- “Дезирит” ОУБ-аас 74,500.0 мянган төгрөгийн ухаалаг худгийн төхөөрөмж, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 75,264.5 мянган төгрөгийн цэвэр усны шугамын насос, 86,825.2 мянган төгрөгийн үзлэгийн худаг, ОНХС-ийн эх үүсвэрээр худалдан авсан 330,000.0 мянган төгрөгийн экскаватор, 132,008.3 мянган төгрөгийн бохир усны шугамыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авсан,
- Аймгийн ОНӨГ-ын шийдвэрийн дагуу барилга, худаг услалтын системд дахин үнэлгээг Сор үнэлэмж ХХК-иар хийлгэснээр үндсэн хөрөнгийн үнэлгээ 5,299,736.9 мянган төгрөгөөр буурсан,
- Стандарт хэмжил зүйн хэлтэст 2,333.0 мянган төгрөгийн лабораторийн хаягдлыг шатаах зуухыг шилжүүлсэн,
- Тайлант онд 576,557.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс тус тус шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,968,561.7 мянган төгрөг болж 241,502.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон НДШ-ийн төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Нийт өр төлбөрийн 52.2 хувийг буюу 1,028,493.8 мянган төгрөгийг НДШ-ийн, 44.7 хувийг буюу 879,055.6 мянган төгрөгийг татварын, 2.8 хувийг буюу 54,313.5 мянган төгрөгийг дансны өр төлбөр, 0.3 хувийг буюу 6,698.8 мянган төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Дансны өр төлбөрийн 82.8 хувийг буюу 36,224.4 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжид өгөх бараа үйлчилгээний, 14.1 хувийг буюу 6,152.4 мянган төгрөгийг хувь хүмүүст өгөх, 3.1 хувийг буюу 1,349.5 мянган төгрөгийг ажиллагсад өгөх өр төлбөр тус тус эзэлж байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Сэлэнгэ аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Тайлант оны орлогыг 2,705,970.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 3,552,178.8 мянган төгрөгөөр, алдагдлыг 846,208.7 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,983,477.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,571,435.4 мянган төгрөгийн зардал гарган, 587,957.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,983,477.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөө 26.7 хувиар тасарсан нь цэвэр усны үнэ тарифыг 6 сараас нэмэгдүүлэх төлөвлөгөө гаргасан боловч 9 сараас үнэ тариф нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардал 2,571,435.4 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан нь тайлант онд халаалтын үнэ тариф нэмэгдсэнээс 12,801.2 мянган төгрөгөөр, “Цант орхон” ААТҮГ-аас зохион байгуулсан туршлага судлах ажил мэргэжлийн уралдаанд 21 хүний бүрэлдэхүүнтэй оролцож төлөвлөөгүй зардал гарснаас томилолтын зардал 8,663.9 мянган төгрөгөөр тус тус хэтэрч, бусад зардлууд хэмнэгдсэнээс шалтгаалан нийт төлөвлөсөн зардлыг 27.6 хувиар хэмнэсэн байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн болон үндсэн хөрөнгийн ангилалтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,478,244.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 37,173.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт - 6 удаа,
- Дараа жилийн зорилтот түвшин- 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан- 1 удаа,

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Шууд худалдан авах болон харьцуулалтын аргын босго үнээс давсан 100,441.7 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бус НИК ХХК-тай шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийн 1: "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-70.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэх .

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 305,378.5 мянган төгрөгөөр,
- Цахилгааны зардлыг 57,222.2 мянган төгрөгөөр,
- Шатахууны зардлыг 20,538.2 мянган төгрөгөөр,
- Даатгалын зардлыг 4,687.8 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 114,548.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 22/60 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 41,275.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 27,020.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 14,254.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	27,020.8	2	27,020.8	100.0
Албан шаардлага	2	14,254.6	2	14,254.6	100.0
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	7	41,275.4	7	41,275.4	100.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

- Тус ААТҮГ нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нь удирдлага, менежментийн үйл ажиллагаатай холбоотой эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх эсэхийг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.
- Санхүүгийн тайланд тайлагнагдсан 1,856,719.8 мянган төгрөгийн авлага, 1,968,561.7 мянган төгрөгийн өр төлбөрт дүн шинжилгээ хийж, барагдуулах, хариуцагч нь тодорхой бус, нас барсан зэрэг барагдуулах боломжгүй олон жилийн насжилттай авлага, өр төлбөрийг холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлж, данс бүртгэлээс хасах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

5. Аудитын илрүүлэлт :

5.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой нийт 305,345.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 162,089.7 мянган төгрөгийн “Цэвэр усны шугамын насос суурилуулах”, “Үзлэгийн худаг угсрах” ажлууд, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 132,008.3 мянган төгрөгийн “Бохир усны шугамын ажил” зэрэг нийт 294,098.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй орхигдуулсан,
- Тоолуурын борлуулалтын орлогын НӨАТ-г салгаж тайлагнаагүйгээс “Орлогын дэлгэрэнгүй тайлан”-д борлуулалтын орлогыг 660.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд 464.0 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр, 10,123.2 мянган төгрөгийн урьдчилж орсон усны орлогыг тус тус дансны өр төлбөрөөр тайлагнасан гэх мэт.

Аудитаар нийт **996,531.4** мянган төгрөгийн 5 зөрчил¹ илрүүлснээс 1,595.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 722,492.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 272,443.7 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

1. Холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүй гэх үндэслэлээр ерөнхий нягтлан бодогч Г.Сувдад 1,595.3 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

99.1 дэх "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.3 Албан шаардлага

1. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг 722,492.4 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан "Сэлэнгэ цэнгэг ус" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө" -г тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлого зарлагын төлөвлөгөөг тооцоо судалгаан дээр үндэслэн бодитоор төлөвлөж, биелэлтийг ханган ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант хугацааны эцэст татвар болон нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс санхүүгийн тайланд татварын өр төлбөр 177,315.5 мянган төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын өр төлбөр 12,972.6 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", "20.2.7 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татвар, НДШ-ийн тооцоог холбогдох байгууллагуудтай нийлж, өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх.

5.4 Зөвлөмж

1. Хоолны зардлын талаар

1.1 Илрүүлэлт: Холбогдох албан тушаалтны тушаал шийдвэр, төсөв, хүчин төгөлдөр төлбөрийн баримт зэрэг анхан шатны баримтгүйгээр зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй 17,570.1 мянган төгрөгийн хоолны зардал гаргасан боловч ХХОАТ тооцож, суутгаагүй байна.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь "Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх", 13.2.10 дахь "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шууд бус орлогод хувь хүний орлогын албан татвар ногдуулж, суутгасан байх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйл: Шууд бус орлого-ын 11.2 дахь "Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамруулахгүй", 11.2.1:

“цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төлөвлөгөөний дагуу зардал гаргах, анхан шатны баримтыг бүрдүүлж, хууль тогтоомжийг мөрдөн ажиллах.

2. Үндсэн хөрөнгийн ангилал

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилалгүйгээр машин, тоног төхөөрөмж дансанд 11,111.1 мянган төгрөгийн компьютер, принтерүүд, тавилга эд хогшил дансанд 30,059.9 мянган төгрөгийн компьютер, зөөврийн компьютер, принтерүүд, 1,994.6 мянган төгрөгийн хангамжийн материал, 21,479.9 мянган төгрөгийн телевизор, хөргөгч, камер зэрэг тоног төхөөрөмжүүдийг бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт 9.Үндсэн хөрөнгө “Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна”, (в) “Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд”, (д) “Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд”, (е) “Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилан бүртгэлд тусгаж байх, хөрөнгийн ангиллыг 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Хөрөнгө оруулалтаар хийгдсэн цэвэр, бохир усны шугамын ажлыг хөрөнгөөр бүртгээгүй, орхигдуулсан	1	294,098.0	1	294,098.0			1	294,098.0				
НӨАТ салгаж бүртгээгүйгээс орлогын дэлгэрэнгүй тайлан борлуулалтын орлого дутуу тусгагдсан	1	660.6			1	660.6	1	660.6				
Өр төлбөрийг буруу тайлагнасан	1	10,587.2			1	10,587.2	1	10,587.2				
Дүн	3	305,345.8	1	294,098.0	2	11,247.8	3	305,345.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин давхардуулан олгосон	1	1,595.3	1	1,595.3								
Төлөвлөсөн орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	722,492.4			1	722,492.4						
Өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй	1	190,288.1			1	190,288.1						
Нотлох дэмжих баримтгүй хоолны зардал гаргасан	1	17,510.1					1	17,510.1				
Үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэсэн	1	64,645.5					1	64,645.5				
Дүн	5	996,531.4	1	1,595.3	2	912,780.5	2	82,155.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг 8 удаа хоцроосон	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2						1	